



29

ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 1/44

Шивээговь сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай биохимиийн шинжилгээний бүрэн автомат анализатор худалдан авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

П.Ганчимэг

(Эрүүл мэндийн төвийн дарга)

Гишүүн:

А.Даваасүрэн

(Эрүүл мэндийн төвийн лаборант)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Эрүүл мэндийн төвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Биохимиийн шинжилгээний бүрэн автомат анализатор” худалдан авах үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, бараа бүтээгдэхүүнийг шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу хүлээн авч, тайлагнахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА



42124 197